

ЭЛСЭЛТИЙН ШАЛГАЛТ-2025 НИЙГМИЙН УХААН

ЯВЦЫН ҮНЭЛГЭЭ Хувилбар А

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

Санамж: Нэгдүгээр хэсэг нь 56 сонгох даалгавартай нийт 80 оноотой. Даалгавар тус бүр 5 сонгох хариулттай. Тэдгээрийн зөвхөн нэг зөв хариултыг сонгож хариултын хуудсанд будаж тэмдэглээрэй. **Хариултын хуудасны заавартай сайтар танилцаарай.** Амжилт хүсье.

1. Цэгийн оронд тохирох хариултыг сонгоорой. /1 оноо/
..... гэдэг нь хүн нийгмийн харилцаанд бие даан оролцох, нийгмийн үйлдлүүдийг хийх чадварыг эзэмших, нийгмээс хүлээж буй шаардлагыг биелүүлэх чадамжтай болох үйл явц юм.

A. Нийгэмшилтийн адилсал B. Нийгэмшилтийн агент C. Нийгмийн байр суурь
D. Нийгмийн бүтэц E. Нийгэмшилт

2. “Тухайн нийгэмд зонхилж байгаа үнэлэмжийн дагуу хүмүүс бусад хүмүүсээр үнэлэгдэж зэрэглэгдэж байдаг” гэж аль онолын ямар эрдэмтэн үзсэн бэ? /1 оноо/

A. Шүүмжлэлт онол – К.Маркс B. Бүтэц чиг үүргийн онол – Дэвис, Мур
C. Бүтэц чиг үүргийн онол – Л.Уорнер D. Бүтэц чиг үүргийн онол – Т.Парсонс
E. Бэлгэ тэмдгийн харилцан үйлдлийн онол – Ж.Г.Мид

3. Эдийн засгийн институтын үүрэгт хамаарах ойлголтуудыг сонгоно уу. /1 оноо/

1. Хэрэгцээт бараа үйлчилгээгээр хангах 2. Нийгмийн эв нэгдлийг тогтоох
3. Бүлэг болон нийгмийг зохицуулах 4. Боловсон хүчнийг бэлтгэх
5. Эдийн засгийг тогтвортой байлгах 6. Татварын хэмжээг бууруулах

A. 1, 2, 4 B. 1, 3, 5 C. 1, 5, 6 D. 2, 5, 6 E. 2, 4, 5

4. Нийгмийн давхраажилтын хэв маягуудын нэг болох “Язгуур”-ын тухай ойлголтуудын аль хэсгийн, ямар дараалалд алдаа байгааг олоорой. /1 оноо/

Хэсэг	А	Б	В
1-р хэсэг	Гэрлэлт харьцангуй нээлттэй.	Хэргэм зэргийг худалдаж авах замаар байр сууриа өөрчилдөг.	Улс төрийн үйл ажиллагаанд оролцох эрхээрээ ялгаатай.
2-р хэсэг	Аж үйлдвэржсэн нийгмийн үед оршин байсан.	Дайн тулаан өр төлөөс, тоталитар дэглэмийн нөлөөгөөр үүсэж болдог.	Байр суурь нь угсаа залгамжлах замаар олгогддог.

A. 1-р хэсэг – В; 2-р хэсэг – Б
C. 1-р хэсэг – Б; 1-р хэсэг – В
E. 1-р хэсэг – А; 2-р хэсэг – А
B. 2-р хэсэг – А; 2-р хэсэг – Б
D. 2-р хэсэг – Б; 2-р хэсэг – В

5. Дараах ойлголтуудаас чанарын судалгаанд аль нь хамаарах вэ? /1 оноо/

1. Цөөн тооны хувьсагч хоорондын хамаарлыг шалгахад анхаарна.
2. Судлагчдын яриа, үйлдлээс хамаарсан олон тооны хувьсагч байна.
3. Мэдээлэл цуглуулах үйл явц нэг ижил горимоор явагдана.
4. Хэмжилт мэдээлэл цуглуулах явцад эсвэл дараа нь хийгдэнэ.
5. Математик статистикийн аргуудаар шинжилгээ хийнэ.

A. 3, 5 B. 2, 3 C. 2, 4 D. 4, 5 E. 1, 4

6. Дараах хүснэгтээс эх олонлогийн тодорхойлолт болон жишээг олно уу. /1 оноо/

Хүснэгт-а		Хүснэгт-б	
1	Судалгаа чиглэж бүх нэгжүүдийг хэлнэ.	1	Зорилгод тулгуурлан судалгаанд оролцогчдыг сонгох
2	Эх олонлогийг бүхэлд нь хамруулах судалгаа.	2	Хүн ам, орон сууцны тооллого явуулах судалгаа
3	Эх олонлогийг бүхэлд нь бус дэд хэсгийг хамруулан судлах.	3	Нийслэлийн өрхийг судлах бол УБ хотын бүх өрх хамаарна.

A. а-2, б-2 B. а-1, б-3 C. а-3, б-1 D. а-2, б-1 E. а-1, б-2

7. Мэдээлэл цуглуулах аргуудыг тохирох өгөгдөлтэй нь зөв харгалзуулна уу. /2 оноо/

а) Ганцаарчилсан ярилцлага	1	Баримт бичгээс тодорхой утгын нэгжийг хувьсагчаар сонгон, давтамж, хоорондын хамаарлыг статистик шинжилгээ ашиглан шинжлэх арга.
	2	Судалгаанд оролцогчоос асуулт асуух замаар мэдээлэл цуглуулах арга.
б) Бүлгийн ярилцлага	3	Тодорхой сэдэв, асуудлыг бүлгийн хүрээнд хэлэлцүүлэг өрнүүлэх замаар мэдээлэл цуглуулах арга юм.
с) Ажиглалт	4	Судалгаанд оролцогчдын зан үйл, үйлдэл, зан төлөв, үг яриа, хөдөлгөөн зэргийн талаар тэмдэглэл хөтлөх замаар мэдээлэл цуглуулах арга.
	5	Сонирхож буй хувьсагч хоорондын хамаарлыг илрүүлэхээр зохиомол орчин бүрдүүлэх замаар судлах арга

A. а3, б1, с4 B. а3, б2, с5 C. а2, б3, с5 D. а2, б3, с4 E. а5, б4, с1

8. XVIII зууны сүүлчээр үүссэн, төрийн удирдлага нь бюрократ байгууллагын тогтолцоо, зэвсэгт хүчинд суурилсан байдаг бөгөөд гэр бүл, шашны институтын үүрэг суларсан нийгмийн байгуулал аль нь вэ? /1 оноо/

A. Цэцэрлэг аж ахуйн нийгэм B. Ан агнуурын нийгэм
C. Газар тариалангийн нийгэм D. Аж үйлдвэржсэний дараах нийгэм
E. Аж үйлдвэржсэн нийгэм

9. Т.Билтон нарын тодорхойлсон “Уламжлалт буюу аж үйлдвэржилтээс өмнөх нийгэм”-ийн шинжүүдийг олоорой. /2 оноо/

Уламжлалт буюу аж үйлдвэржилтээс өмнөх нийгэм	1	Шинжлэх ухааны итгэл үнэмшлийн тогтолцоо тэргүүлэх үүрэгтэй.
	2	Хувийн хүсэл зориг гэхээсээ нийгэм-хамт олны зарчимд нийцүүлэн хувь хүн амьдардаг.
	3	Хүний амьдралын үйл ажиллагааны гол талбар нь өрх гэр, гэр бүлийн хүрээ байна.
	4	Нийгэм-хамт олны зарчимд нийцүүлэх гэхээсээ хувийн хүсэл зоригийг хэрэгжүүлэхийг эрхэмлэдэг.
	5	Олон нийтийн байгууллагын хүрээнд олон янзын үүрэг хүлээж, олон талт харилцаа бүхий байна.

A. 4, 5 B. 3, 4 C. 1, 5 D. 2, 3 E. 2, 5

10. Соёлын бүрдэл элементүүдийн нэг болох “Хэм хэмжээ”-ний тухай жишээг олоорой. /1 оноо/
- A. Шударга ёс, хүний эрх, эрдэм боловсрол
 - B. Үлгэр домог, шашин, урлаг, шинжлэх ухаан
 - C. Дэг журам, хууль дүрэм, ёс заншил
 - D. Тэмдэглэсэн үг, өгүүлбэр, бичвэр, дохио зангаа
 - E. Ард Аюушийн хөшөө, Чингис хааны хөшөө

11. “Үнэлэмжийн баримжаа” гэсэн ойлголтын тухай тайлбарыг олоорой. /1 оноо/
- A. Бид аливаа үйл явдал, үзэл санааг дэмжих, буруутгах, шүүмжлэх, магтах зэргээр янз бүрээр үнэлж, дүгнэж байдаг.
 - B. Хүмүүс үзэл санаа, итгэл үнэмшил, ёс суртахууны хувьд харилцан адилгүй сонголт хийдэг.
 - C. Нийгэмд үйлчилж байдаг хэм хэмжээг эзэмшсэнээс хүмүүс амьдралын чиг баримжаагаа олж авдаг.
 - D. Өмнөх үеийг бүтээсэн нийгэм-соёлын уламжлалыг өвлүүлэх нь нийгмийн оршихуйн үндэс юм.
 - E. Зохистой сайхан хувцаслахаас эхлээд муу үйл үйлдэж болохгүй гэх зэрэг өргөн агуулгатай.

12. Нийтийн соёлд хамаарах жишээг олоорой. /1 оноо/

1. Дуу, бичлэг	2. Хэвлэл, мэдээллийн хэрэгсэл	3. Поп, хит дуу
4. Ардын дуу, бүжиг	5. Симфони найрал хөгжим	6. Бүжгийн жүжиг

- A. 2, 5, 6 B. 1, 3, 6 C. 1, 3, 5 D. 1, 2, 3 E. 3, 4, 6

13. Соёлын өвийн тухай ойлголтуудын аль хэсгийн, ямар дараалалд алдаа байгааг олоорой. /2 оноо/

Хэсэг	A	Б
1-р хэсэг	Соёлын өв нь тухайн үндэстний соёлын нэгдмэл байдлыг бий болгодог.	Соёлын өв нь дэлхийн соёлын олон янз байдлыг бий болгодоггүй.
2-р хэсэг	Олон жилийн туршид ихэвчлэн биет өвийг хамгаалахад анхаарч байсан.	Сүүлийн жилүүдэд биет бус өвд анхаарал хандуулах болсон.

- A. 1-р хэсэг – А; 2-р хэсэг – Б B. 1-р хэсэг – А C. 2-р хэсэг – Б
D. 2-р хэсэг – А E. 1-р хэсэг – Б

14. Монгол улс “Соёлын үйлдвэрлэл” үндэсний хөтөлбөрийг 2015 онд батлан хэрэгжүүлж эхэлсэн. Энэхүү хөтөлбөрт тусгасан хэсгийг олоорой. /2 оноо/

Хэсэг	A	Б
1-р хэсэг	Соёлын солилцоонд тулгуурлах	Улс үндэстнийхээ өв уламжлал, байгалийн дүр төрх, соёлын нөлөөг сэргээх
2-р хэсэг	Хүн амын амьжиргаа болон хөгжилд үр ашгаа өгөх	Өөрийн орны ёс заншил, өв уламжлалыг дэлхий нийтэд таниулах сурталчлах

- A. 1-р хэсэг – Б; 2-р хэсэг – А B. 1-р хэсэг – А; 2-р хэсэг – А
C. 1-р хэсэг – А; 1-р хэсэг – Б D. 1-р хэсэг – Б; 2-р хэсэг – Б
E. 1-р хэсэг – А; 2-р хэсэг – Б



15. Цэгийн оронд тохирох хариултыг сонгоорой. /1 оноо/
- Хүснэгт дэх жишээг ажиглаад, соёлын өөрчлөлтөд нөлөөлөх хүчин зүйлсийн бүдүүвчийг гүйцээгээрэй.

Соёлын өөрчлөлт	1876 онд телефон утас зохион бүтээгдэв.
	Дэлхийн дулаарал, байгаль цаг уурын онцлог

- A. Нуур цөөрөм ширгэх, цөлжилт явагдах
- B. Зохисгүй хэрэглээ, авлига, гэмт хэрэг ихсэх
- C. Монголчууд шинэ жилийн баяр тэмдэглэх болсон
- D. Буруу хэвшил, шударга бус явдал ихсэх
- E. Өндөр хэрэглээнд хэт их ач холбогдол өгөх

16. Цэгийн оронд тохирох хариултыг сонгоорой. /1 оноо/
- Зам харилцаа, эдийн засгийн харилцаа, мэдээлэл харилцааны хөгжлийн үндсэн дээр тусгаар соёлууд дэлхийн нэгдмэл соёлд нэгдэн нийлэх үйл явцыг гэнэ.
- A. соёлын үйлдвэрлэл B. соёлын даяаршил C. соёлын адилсал
 - D. соёлын дархлаа E. соёлын нэвчилт


17. Соёлын эрх чөлөөний зөрчих хандлагыг сонгоорой. /2 оноо/

Соёлын эрх чөлөөний зөрчих хандлага	1	Амьдралын хэв маягийг үгүйсгэх
	2	Бүх соёлыг ижил тэгш үнэлж, хүндэтгэх
	3	Хувь хүний сонголт хийх бололцоог өргөжүүлэх
	4	Нийгмийн амьдрал дахь оролцоог хязгаарлах
	5	Өөрийн соёлын бүтээн туурвих бололцоог эдлэх

- A. 2, 3 B. 1, 5 C. 1, 4 D. 2, 5 E. 4, 5

18. Дараах тохиолдлыг уншаад “Харь соёлд дасан зохицох үе шат”-ын аль үе шат дээр явж буйг тодорхойлоорой. /2 оноо/

График №1 /Харь соёлд дасан зохицох үе шат/



Тохиолдол

Болд ШУТИС -ийг 2023 онд төгссөн бөгөөд АНУ-д үргэлжлүүлэн суралцахаар болов. 2024 оны 3-р сард АНУ-д очоод тухайн улсын соёлд дассан боловч эргэн тойрныхоо хүмүүстэй харилцаа тогтоож чадахгүй байсан.

- A. F-үе шат B. G-үе шат C. C-үе шат D. E-үе шат E. A-үе шат

19. Цэгийн оронд тохирох хариултыг сонгоорой. /1 оноо/
- нь тодорхой хэмжээний мөнгийг тогтоосон хугацааны дараа, зохих хүүтэйгээр эргүүлэн төлөхөө амлаж байгааг баталсан үнэт цаас юм.
- A. Брокер B. Хувьцаа C. Хувьцааны ханш D. Хөрөнгийн бирж E. Бонд

20. Мөчлөгийн ажилгүйдлийн жишээг олно уу. /1 оноо/
 А. Г нь барилга дээр ажилладаг ч өвлийн улиралд ажил нь түр хугацаагаар зогссон тул түр хугацаагаар ажилгүй байгаа.
 В. Уул уурхайн салбарын хөрөнгө оруулалт буурсантай холбоотой томоохон уурхай хаагдаж олон уурхайчид ажилгүй болсон.
 С. Инженер Х нь албан тушаал дэвшиж, Батлан хамгаалах яаманд ажиллах болсон тул түр хугацаанд ажилгүй болсон.
 Д. Иргэдийн худалдан авалт муудаж, олон үйлдвэрийн газар хаалгаа барьснаас иргэн Х ажилгүй болсон.
 Е. О-н нөхөр нийслэлд ажиллахаар томилогдсон тул О нь хотод ирээд хэсэг хугацаанд ажилгүй болсон.

21. Бизнесийн төлөвлөгөөний бүтэц, үе шатын нэг болох "Санхүүгийн тооцоо" хэсэгт хамаарч буй ойлголтыг олоорой. /1 оноо/

- | | |
|-------------------------------|------------------------|
| 1. Бизнесийн давуу тал | 2. Борлуулалтын орлого |
| 3. Бизнесийн хөрөнгө оруулалт | 4. Үр ашиг, татвар |
| 5. Бизнесийн хүрэх үр дүн | 6. Хэлбэр, байршил |

- A. 3, 5 B. 1, 6 C. 2, 4 D. 2, 6 E. 1, 3

22. Хүснэгт дэх мэдээллээс Д.Кейнсийн үзэл баримтлалыг олоорой. /2 оноо/

Хэсэг	А	Б
1-р хэсэг	Мөнгөний хэмжээ үнийн түвшний хооронд шууд холбоо байхгүй.	Зах зээлийн тогтолцоо нь эдийн засгийн уналтаас өөрийгөө аварч чадахгүй.
2-р хэсэг	Төрийн идэвхтэй оролцоо нь эдийн засагт хор учруулна.	Төрийн оролцоотой нийт эрэлтийг нэмэгдүүлэх ёстой.

- A. 1-р хэсэг – А; 2-р хэсэг – А B. 1-р хэсэг – Б; 2-р хэсэг – Б
 C. 1-р хэсэг – А; 1-р хэсэг – Б D. 1-р хэсэг – Б; 2-р хэсэг – А
 E. 1-р хэсэг – А; 2-р хэсэг – Б

23. 2023 онд Монгол улсын экспорт нь 710 тэрбум төгрөг, импорт нь 620 тэрбум төгрөг байсан бол тус оны МУ-ын гадаад худалдааны тэнцлийг тооцоолно уу. /1 оноо/
 A. 1330 B. -90 C. -1330 D. 90 E. 1240

24. Мөнгөний үндсэн шинжид аль нь хамаарах вэ? /1 оноо/
 A. Хуваагдмал нэгжтэй байх B. Төлбөрийн хэрэгсэл C. Өртгийн хэмжүүр
 D. Хуримтлалын хэрэгсэл E. Арилжааны буюу гүйлгээний хэрэгсэл

25. Иргэн Б сард 1 сая 500 мянган төгрөгний цалин авдаг. Захирал нь урамшуулал болгон түүний цалинг 200 мянган төгрөгөөр нэмэгдүүлэх шийдвэр гаргасан. Гэтэл энэ үед бараа үйлчилгээний үнийн түвшин 12 хувиар өссөн. Энэ тохиолдолд түүний бодит цалин хэд вэ? /2 оноо/
 A. 1,517,857 төгрөг B. 1,539,285 төгрөг C. 1,520,000 төгрөг
 D. 1,339,285 төгрөг E. 1,931,818 төгрөг

26. Хөдөлмөрийн зах зээлд цалингийн түвшин 600 мянган төгрөг болж өсөхөд хөдөлмөрийн нийлүүлэлт 500 нэгж байсан. Энэ үед хөдөлмөрийн эрэлт 100 нэгж байхад ямар үзэгдэл бий болох вэ? /2 оноо/

- A. Ажиллах хүчний илүүдэл бий болно (600 нэгжээр өссөн)
 B. Ажиллах хүчний хомсдол бий болно (400 нэгжээр буурсан)
 C. Ажиллах хүчний илүүдэл бий болно (200 нэгжээр өссөн)
 D. Ажиллах хүчний хомсдол бий болно (200 нэгжээр буурсан)
 E. Ажиллах хүчний илүүдэл бий болно (400 нэгжээр өссөн)

27. ДНБ-ий өсөлтийг онуудаар харуулж буй хүснэгтийг ажиглаад "Абсолют цэвэр өсөлт" болон "Өсөлтийн хурд"-ыг тооцоолоорой. /2 оноо/

Дараах томъёонуудаас сонгон бодолтыг хийгээрэй.

$$Y_n - \text{Тухайн оны үзүүлэлт}; \quad Y_{n-1} - \text{Өмнөх оны үзүүлэлт}$$

$$Y_n - Y_{n-1}; \quad \frac{Y_n}{Y_{n-1}}; \quad \frac{Y_n}{Y_{n-1}} \times 100\%; \quad \frac{Y_n}{Y_{n-1}} \times 100\% - 100\%;$$

Он	Үсгэн тэмдэглэгээ	ДНБ, тэрбум төгрөг	Абсолют цэвэр өсөлт	Өсөлтийн хурд
2022	Y_{2022}	21,900,0	-	-
2023	Y_{2023}	24,800,0	a.....	b.....

- A. a-2,900,0; b-13 B. a-113; b-2,900,0 C. a-1.13; b-2,900,0
 D. a-2,900,0; b-1.13 E. a-2,900,0; b-113

28. Цэгийн оронд тохирох хариултыг сонгоорой. /1 оноо/
 нь УИХ-ын зохион байгуулалтын үндсэн хэлбэр юм.
 A. Хэлэлцүүлэг B. Мэтгэлцээн C. Чуулган D. Хэвлэл мэдээлэл E. Уулзалт

29. Цэгийн оронд тохирох хариултыг сонгоорой. /1 оноо/
 Манай улс анхдугаар үндсэн хуулиа батлан гаргасан.
 A. 1924 онд B. 1940 онд C. 1960 онд D. 1990 онд E. 1992 онд

30. "Шууд ардчилал" гэсэн ойлголтыг аль нь илэрхийлж байна вэ? /2 оноо/
 A. Олон түмэн өөрөө өөрийгөө удирдаж, иргэн бүрийг төрийн хэрэгт оролцуулдаг.
 B. Албан тушаалтныг сонгож, түүгээр дамжуулж засаглалыг хэрэгжүүлэх хэлбэр.
 C. Улс төрийн тогтолцоог мэргэшиж, туршлагажсан хүмүүс удирдан зохион байгуулдаг.
 D. Иргэд төрийн хэрэгт шууд оролцохгүй тул улс төрийн идэвх буурах талтай.
 E. Төлөөлөгчид нь иргэдийн санал бодлыг тэр болгон бүрэн илэрхийлдэггүй.

31. 1990 оны дараах төрийн бодлогуудыг сонгоорой. /2 оноо/

Хэсэг	А	Б
1-р хэсэг	Хүний эрхийн түгээмэл зарчмуудыг бодитой хэрэгжүүлж эхэлсэн	Үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөнд хэм хэмжээ тогтоох
2-р хэсэг	Ардчилсан зарчмыг улс төр, үзэл суртлын компани болгож төлөвлөх	Аливаа хэм хэмжээ, эрх чөлөөгөө хяналтгүйгээр хуулийн хүрээнд эдлэх

- A. 1-р хэсэг – Б; 2-р хэсэг – А B. 1-р хэсэг – А; 2-р хэсэг – А
 C. 1-р хэсэг – А; 1-р хэсэг – Б D. 1-р хэсэг – Б; 2-р хэсэг – Б
 E. 1-р хэсэг – А; 2-р хэсэг – Б

32. Д.Истоны улс төрийн системийн оролтын нэг болох "Оролцооны дэмжлэг" гэсэн ойлголтыг аль нь илэрхийлж байна вэ? /2 оноо/
- A. Татвар төлөх, төрийн болон цэргийн алба хаших, хууль дүрмийг дагаж мөрдөх
 B. Төрийн бодлогын тодорхой илрэл болсон төрийн хууль тогтоомж, мэдээлэл зэрэг
 C. Нийгмийн хурцадмал, тогтворгүй байдлыг арилгах гол механизмын үүргийг гүйцэтгэдэг
 D. Аль нэг нам, нэр дэвшигчийн төлөө санал өгөх, шийдвэрийг дэмжиж буйгаа илэрхийлэх
 E. Улс төрийн систем, түүнийг хүрээлэн байгаа экологи, соёл зэрэг янз бүрийн тулгалтууд

33. Мэдээлэл харилцааны дэд системд тохирох өгөгдлийг сонгоно уу /2 оноо/

Мэдээлэл харилцааны дэд систем	1	Улс төрийн системийн бүрдэл хооронд холбоо тогтоох
	2	Хүмүүсийн үйлдэл болон бусад объектын чиг үүргийг тодорхойлдог.
	3	Төр, нам, сонирхлын бүлэг зэрэгтэй хамгийн түрүүнд холбогддог.
	4	Төр болон улс төрийн институтэд мэдээлэл дамжуулах үүрэгтэй.
	5	Хууль тогтоох үйл явцыг тодорхойлж саналаа хэлэх эрхийг тогтооно.

- A. 3, 4 B. 1, 5 C. 1, 4 D. 2, 5 E. 2, 4

34. "Улс төр бол нийгэм дэх үнэт зүйлсийг эрх мэдэлд тулгуурлан хуваарилан байршуулах үйл явдал юм" гэж хэн үзсэн бэ? /1 оноо/
- A. Макиавелли B. Истон C. Локк D. Монтескье E. Даль

35. Ардчилсан сонгуулийн бүх нийтээр оролцох зарчмыг аль нь илэрхийлж байна вэ? /1 оноо/
- A. Сонгуульд оролцохдоо чөлөөтэй сонголт хийн, саналаа чөлөөтэй илэрхийлдэг байх
 B. Сонгогч бүр ижил тооны санал гаргах эрхтэй бөгөөд санал бүр адил жинтэй байх
 C. Сонгуулийн үр дүн нь зөвхөн иргэдийн санал хураалтын үр дүнгээр шийдэгддэг байх
 D. Нас, хүйс, яс үндэс, гарал угсаа зэрэг үзэл бодлоос үл шалтгаалан бүгд оролцдог байх
 E. Сонгогч ямар нэгэн дарамт шахалтгүйгээр өөрийн үзэмжээр саналаа өгдөг байх

36. Улс төрийн намын нийгэмд гүйцэтгэх үүрэгт аль аль нь хамаарах вэ? /2 оноо/

Хэсэг	А	Б
1-р хэсэг	Улс орны хөгжлийн бодлогыг тодорхойлох, хэрэгжүүлэх	Нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд иргэдийн боломжийг хязгаарлах
2-р хэсэг	Намын дотоод ардчиллыг хангах	Төрийн байгууллагын бүрэлдэхүүнд сонгогдох эрхтэй

- A. 1-р хэсэг – Б; 2-р хэсэг – А B. 1-р хэсэг – А; 2-р хэсэг – Б
 C. 1-р хэсэг – А; 1-р хэсэг – Б D. 1-р хэсэг – Б; 2-р хэсэг – Б
 E. 1-р хэсэг – А; 2-р хэсэг – А

37. Хувийн эрх ашгийн төлөө бус, бүлгийн буюу нийтийн ашиг сонирхлыг илэрхийлэх зорилгоор иргэдээс сайн дураараа үүсгэн байгуулсан байгууллага, хөдөлгөөнийг юу гэж нэрлэдэг вэ? /1 оноо/
- A. Сонирхлын бүлэг B. Улс төрийн нам C. Лобби бүлэг
 D. Шахалтын бүлэг E. Аномик бүлэг

38. Төр бол "зайлшгүй байх ёстой муу зүйл" юм гэж хэн үзсэн бэ? /1 оноо/
- A. Ж.С.Милль B. Л.Актон C. Р.Нозик D. Ж. Локк E. Т.Гоббс

39. Доорх ойлголтуудаас хүний эрхэм чанарт аль нь хамаарахгүй вэ? /1 оноо/
- A. Хүний эрхэм чанарт халдаж болохгүй.
 B. Хүний эрхэм чанар нь хүн бүрд адилхан байдаг.
 C. Хүнээс хүний эрхэм чанарыг нь салгаж болдоггүй.
 D. Хүний эрхэм чанар нь заяагдмал бус шинжтэй.
 E. Хүний эрхэм чанар нь үл хэмжигдэх үнэт зүйл.

40-42 дугаар даалгаврыг доорх кэйсийг уншиж гүйцэтгээрэй.

Иргэн Б 34 настай бөгөөд "UB" корпорацид 13 сар тасралтгүй ажиллаж нийгмийн даатгалын шимтгэлийг төлсөн. Б нь удирдлагын хэлтэсийн санаачилгаар амралтын 2 өдөр илүү цагаар ажилласан. Гэвч цалин олгоход илүү цагийн хөлсийг иргэн Б-д олгоогүй. Үүнээс хойш 2 сарын дараа Б ажил дээрээ 1 сарын хугацаанд гурван удаа сахилгын зөрчил давтан гаргажээ.

40. Ажил олгогч нь иргэн Б-г ажлаас чөлөөлөх үндэслэлтэй юу? /1 оноо/
- A. Б нь хөдөлмөрийн сахилгын зөрчлийг ноцтой зөрчөөгүй бол хэдэн ч удаа зөрчил гаргах үндэслэлтэй
 B. Б нь хөдөлмөрийн сахилгын зөрчил гаргасан тул ажил олгогч ажилтанг ажлаас чөлөөлөх үндэслэл гаргах боломжгүй.
 C. Б хөдөлмөрийн сахилгын зөрчлийг давтан гаргасан тул хөдөлмөрийн харилцааг шууд зогсоож болно..
 D. Ажил олгогч нь ажилтанг ажлаас чөлөөлөхдөө хөдөлмөрийн тухай хуулийн 53-р зүйлийг баримталж чөлөөлөх ёстой.
 E. Ажил олгогч нь ажилтанг ажлаас чөлөөлөхдөө үндсэн тухай хуулийн 16-р зүйлийг баримталж чөлөөлөх ёстой.
41. Иргэн Б-д "UB" корпораци илүү цагийн хөлсийг олгох ёстой юу? /2 оноо/
- A. 7 хоногт 40 цаг хүртэл ажилласан бол хөдөлмөрийн тухай хуулийн 53-р зүйлийн 1-д зааснаар илүү цагийн хөлсийг олгох ёстой.
 B. Удирдлагын хэлтсийн санаачилгаар илүү цагаар ажилласан тул илүү цагаар ажилласанд тооцдоггүй.
 C. "UB" корпораци нь үндэстэн дамнасан корпораци учир илүү цагийн мөнгийг монголын хөдөлмөрийн тухай хуулиар олгодоггүй.
 D. Тухайн сарын ажлын бүх өдөр илүү цагаар ажиллавал хөдөлмөрийн тухай хуулийн 53-р зүйлийн 1-д зааснаар илүү цагийн хөлсийг олгох ёстой.
 E. Ажил олгогчийн санаачилгаар хэтрүүлэн ажиллахыг илүү цагаар ажилласанд тооцдог тул илүү цагийн хөлс олгох ёстой.

42. Хэрвээ иргэн Б нь жирэмсэн байсан бол жирэмсэн болон амаржсаны тэтгэмжийг цалингийн хэдэн хувиар тооцон нийгмийн даатгалын сангаас авах ёстой вэ? /2 оноо/
- A. 10 сарын цалингийн дунджийг 70 хувиар тооцож 4 сарын цалин авна.
 B. 12 сарын цалингийн дунджийг 70 хувиар тооцож 4 сарын цалин авна.
 C. 10 сарын цалингийн дунджийг 100 хувиар тооцож 4 сарын цалин авна.
 D. 12 сарын цалингийн дунджийг 100 хувиар тооцож 4 сарын цалин авна.
 E. 3 сарын цалингийн дунджийг 70 хувиар тооцож 4 сарын цалин авна.

43. Захиргааны актын агуулгын шаардлагад хамааралгүй ойлголтыг олно уу. /2 оноо/

Хэсэг	А	Б
1-р хэсэг	Шийдвэрийн хувьд алдаагүй байх	Эрх зүйн хувьд үндэслэлтэй байх
2-р хэсэг	Формаль шаардлагыг хангасан байх	Хаяглагч буюу хандсан этгээдийг зөв сонгосон байх

- A. 2-р хэсгийн А В. 2-р хэсгийн Б С. 1-р хэсгийн А
D. 1-р хэсгийн Б Е. 2-р хэсгийн А, Б

44. Сахилгын шийтгэлд хамаарах жишээнүүдийг сонгоно уу /2 оноо/

Сахилгын шийтгэл	1	Я замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн тул 50 нэгжээр торгуулав.
	2	Ё онгоцны буудал дээр танхайрсан тул баривчлагдав.
	3	С санаатайгаар ажилтнаа хүнд бэртээсэн тул ажлаасаа чөлөөлөгдөв.
	4	Ж согтуугаараа машин жолоодсон тул жолоодох эрхээ хасуулав.
	5	Р зөрчил маргаан үүсгэсэн тул сануулах арга хэмжээ авхуулав.

- A. 3, 5 В. 1, 4 С. 3, 4 D. 2, 5 Е. 2, 4

45. “Ул үндэстэй авч үзэх юм бол эрх гэж байхгүй зөвхөн “өмчлөх эрх” л байдаг гэж хэн үзсэн бэ? /1 оноо/

- A. Р.Нозик В. Э.Дюркгейм С. Н.Ротбард D. Ф.Бастиа Е. Т.Гоббс

46. Өмчлөх эрх үүсэх хуульд заасан үндэслэлүүдийг олоорой. /1 оноо/

- A. Ирээдүйд эд хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ
B. Шүүхийн шийдвэрийн дагуу эд хөрөнгөтэй болох
C. Авто тээврийн хэрэгслийг зөвшөөрөлгүйгээр авч явах
D. Бусдын эд хөрөнгийг хамгаалахад хайнга хандах
E. Болгоомжгүйгээр эд хөрөнгө устгах, гэмтээх, үрэгдүүлэх

47. Улсын Их Хурлын үйл ажиллагааны тухай ойлголтуудын аль хэсгийн, ямар дараалалд алдаа байгааг олоорой. /2 оноо/

Хэсэг	А	Б
1-р хэсэг	Хууль тогтоох замаар хүний эрхийг хангах	Хүний эрхийн талаар хууль тогтоомж олон улсын гэрээний биелэлтийг хангах
2-р хэсэг	Эрх зүйн орчныг бүрдүүлэх, засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавих	Хүний эрх зөрчсөн тухай нэхэмжлэлийг хянан шийдвэрлэх

- A. 1-р хэсэг – А; 2-р хэсэг – А В. 1-р хэсэг – А; 2-р хэсэг – Б
C. 1-р хэсэг – А; 1-р хэсэг – Б D. 1-р хэсэг – Б; 2-р хэсэг – Б
E. 1-р хэсэг – Б; 2-р хэсэг – А

48. Монгол улс бусад улсын улс төр, эдийн засаг, соёлын хүч чадавх, үйл ажиллагааг өөрийн боломжоор хянах, үнэлэх явдлыг юу гэж нэрлэдэг вэ? /1 оноо/

- A. Олон улсын харилцаанд оролцох үйл ажиллагааны чиглэл
B. Олон улсын харилцаанд оролцох үүрэг C. Иргэн олон улсын харилцааны оролцогч
D. Олон улсын харилцаа E. Олон улсын харилцаанд оролцох нөлөө

49. Олон улсын харилцааны улс бус оролцогчдод аль нь хамаарахгүй вэ? /1 оноо/

- A. Бүрэн эрхт улс В. Олон улсын байгууллага С. Шашны байгууллага
D. Нөлөө бүхий хувь хүн Е. Террорист байгууллага

50. Цэгийн оронд тохирох хариултыг сонгоорой. /1 оноо/

- Террорист байгууллагуудын хамгийн алдартай нь 1980-аад онд байгуулагдсан бүлэглэл юм.
A. Аль-Кайда В. Жихад С. Хамас D. Исламын хэт даврагчид Е. BBC

51. Дунд улсын тухай мэдээлэл нь аль хэсгийн, ямар дараалалд алдаагүй байгааг олоорой. /2 оноо/

Хэсэг	А	Б
1-р хэсэг	Олон улсын харилцаанд нөлөө багатай	Хөрш болон бүс нутагтаа баттай нөлөөлдөг
2-р хэсэг	Дэлхийн улсуудын 66 хувийг эзэлдэг	Голчлон тогтвортой эдийн засгийн хөгжилтэй улсууд

- A. 1-р хэсэг – Б; 2-р хэсэг – А В. 1-р хэсэг – А; 2-р хэсэг – Б
C. 2-р хэсэг – Б; 1-р хэсэг – Б D. 2-р хэсэг – А; 2-р хэсэг – Б
E. 1-р хэсэг – А; 2-р хэсэг – А

52. Аль хэсгийн ямар дараалалд зөөлөн хүчний төрлүүдийг дурдсан байна вэ? /2 оноо/

Хэсэг	А	Б
1-р хэсэг	Гадаад бодлого	Эдийн засгийн хориг
2-р хэсэг	Удирдамж	Улс төрийн үнэт зүйл

- A. 2-р хэсэг – Б; 1-р хэсэг – Б В. 1-р хэсэг – А; 2-р хэсэг – Б
C. 1-р хэсэг – Б; 2-р хэсэг – А D. 2-р хэсэг – А; 2-р хэсэг – Б
E. 1-р хэсэг – А; 2-р хэсэг – А

53. Олон улсын байгууллагыг үйл ажиллагааны цар хүрээний ойлголтуудын аль хэсгийн, ямар дараалалд алдаа байгааг тодорхойлоорой. /2 оноо/

Хэсэг	А - /Глобал түвшин/	Б - /Бүс нутгийн түвшин/
1-р хэсэг	Олон улсын Гаалийн шүүх	Исламын улсуудын чуулга уулзалт
2-р хэсэг	НҮБ	НАТО

- A. 1-р хэсэг – А; 2-р хэсэг – Б В. 1-р хэсэг – Б; 2-р хэсэг – Б
C. 1-р хэсэг – А; 1-р хэсэг – Б D. 1-р хэсэг – А; 2-р хэсэг – А
E. 1-р хэсэг – Б; 2-р хэсэг – А

54. NHK, SBS, CCTV гэх мэт байгууллагууд нь улс бус оролцогчдын алинд нь хамаарах вэ? /1 оноо/

- A. Олон улсын гэмт хэргийн сүлжээ В. Олон улсын байгууллага
C. Олон улсын төрийн бус байгууллага D. Олон улсын хэвлэл мэдээллийн сүлжээ
E. Үндэстэн дамнасан корпорац

55. Монгол улсын олон улсын хамтын нийгэмлэг дэх үйл ажиллагааны чиглэлийг зөв дараалалд оруулан эрэмбэлнэ үү? /2 оноо/

- a) Хөгжиж буй орнуудтай нийтлэг зорилтын хүрээнд хамтран ажиллах
 b) Хөрш орнуудтайгаа найрсагаар харилцах
 c) НҮБ болон түүний төрөлжсөн байгууллагууд ОУВС, ДБ, АХБ-тай хамтран ажиллах
 d) Өрнө, дорнын өндөр хөгжилтэй гүрнүүдтэй найрсаг харилцаа хөгжүүлэх
 e) Социализмын дараах орнууд, ТУХН-ийн орнуудтай найрсаг харилцаа хөгжүүлэх
 f) Азийн бүс нутгийн улс төр, эдийн засгийн интеграцид оновчтой оролцох



- A. 1e,2b,3a,4f,5d,6c
 B. 1e,2b,3f,4d,5a,6c
 C. 1b,2a,3f,4d,5c,6e
 D. 1b,2e,3f,4d,5a,6c
 E. 1b,2f,3d,4a,5c,6e

56. Хоёр хөрштэйгөө харилцах чиглэлд аль нь хамаарахгүй вэ? /1 оноо/
 A. Олон тулгуурт
 B. Эдийн засгийн
 C. Боловсролын
 D. Соёлын
 E. Хүмүүнлэгийн

ХОЁРДУГААР ХЭСЭГ

Санамж: Хоёрдугаар хэсэг нь 4 даалгавартай нийт 20 оноотой. **Хариултын хуудасны заавартай сайтар танилцаарай.**

2.1. Дараах ойлголтуудыг тохирох өгөгдөлтэй нь харгалзуулна уу. /5 оноо/

a) Бурангуй үзэл b) Алагчлал c) Шууд алагчлал d) Шууд бус алагчлал e) Тэгш бус байдал	1	Ижил буюу төстэй нөхцөлд нас, хүйс, үндэс угсаа, шашин шүтлэг зэрэг шинжээр ялгаатай байдалд хүргэсэн үйлдэл
	2	Нэг бүлгийнхний зүгээс нөгөө бүлгээ тодорхойлдог үзэл бодол, хандлага
	3	Аливаа шинжүүдээр нь шууд ялгаагүй ч ямар нэг стандарт, хэм хэмжээ, үйлдэл нь ялгаатай байдалд хүргэсэн үйлдэл
	4	Тодорхой хэв шинжит харилцаа бүхий тэгш бус байдлын тогтолцоо
	5	Эдийн засгийн баялаг, нэр хүнд, эрх мэдэлд хүрэх адил бус боломж бүхий байдал
	6	Нэг бүлэгт давуу боломж олгосон атлаа нөгөөгийнх нь боломжийг хааж буй бодит үйлдэл.

2.2. Дараах ойлголтуудыг тохирох өгөгдөлтэй нь харгалзуулна уу. /5 оноо/

a) Улс төрийн нам b) Сонирхлын бүлэг c) Артикуляци d) Агрегаци e) Интеграци	1	Онцгой ашиг сонирхлоо хэрэгжүүлэх зорилгоор төрийн байгууллагуудад зорилго, чиглэл бүхий нөлөө үзүүлэх
	2	Сонирхлын бүлэг нь явцуу олон шаардлагыг цэгцлэн, нэгтгэн боловсруулдаг.
	3	Улс орны хөгжлийн бодлогыг хамтын зарчмаар тодорхойлж, хэрэгжүүлдэг, хариуцлага хүлээх чадвартай иргэдийн эвлэлдэн нэгдсэн байгууллага
	4	Хувийн эрх ашгийн төлөө бус, нийтийн ашиг сонирхлыг илэрхийлэх зорилгоор иргэдээс сайн дураараа үүсгэн байгуулсан байгууллага
	5	Сонирхлын бүлгийн гишүүдийн сонирхлыг нэг үзүүрт чиглүүлэх буюу нэгтгэхэд чиглэсэн үйл ажиллагаа.
	6	Нийгэм дэх олон бүлгийн сонирхлыг илрүүлэн гаргах үндсэн чиг үүрэг болдог.

2.3. Дараах ойлголтуудыг тохирох өгөгдөлтэй нь харгалзуулна уу. /5 оноо/

a) Өргөдөл b) Гомдол c) Хүсэлт d) Нэхэмжлэл e) Захиргааны акт	1	Өөрт болон бусдад тулгарч буй асуудлыг шийдвэрлүүлэх тухай захиргааны байгууллагад хандаж буй баримт.
	2	Иргэдийн хоорондын эд хөрөнгийн ба эд хөрөнгийн бус амины шинжтэй харилцаа.
	3	Эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус баялагтай холбоотой анхан шатны шүүхээр дамжуулан эрх зөрчигчид тавьж буй шаардлага.
	4	Захиргааны байгууллагын буруугаас иргэн, хуулийн этгээдийн эрх нь зөрчигдөж, зөрчигдсөн эрхээ сэргээлгэхээр гаргасан хүсэлт.
	5	Нийтийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор захиргааны байгууллага, албан тушаалтнаас гаргасан шийдвэр.
	6	Тодорхой ажиллагааг эхлүүлэх, эсвэл дуусгавар болгох тухай захиргааны байгууллагад гаргасан хүсэлт.

2.4. Дараах ойлголтуудыг тохирох өгөгдөлтэй нь харгалзуулна уу. /5 оноо/

a) Олон тулгуурт байх b) Идэвхтэй байх c) Тэнцвэртэй байх d) Үндэсний эрх ашигт нийцсэн байх e) Олон улсын харилцаа	1	Олон улс гүрэнтэй хамтран ажиллах, гадаад харилцааг олон хэлбэрээр явуулах.
	2	Үндэсний язгуур ашиг сонирхлыг сахин хамгаалсан үндэсний хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд үйлчилнэ.
	3	Гадаад харилцаа, хамтын ажиллагаандаа нөөц бололцоог аль болох бүрэн дайчлан зохион байгуулах явдал юм.
	4	Засгийн газрын оролцоо, дэмжлэггүйгээр улс, үндэстэн дамнасан үйл ажиллагаа явуулдаг глобал түвшний оролцогчид.
	5	Дэлхийн улс ба улс бус оролцогчид хоорондын олон талт харилцаа, тэдний гадаад бодлого үйл ажиллагааг судалдаг шинжлэх ухаан.
	6	Монгол улсын стратегийн ач холбогдол бүхий гүрнүүдийн монгол дахь эдийн засгийн болон бусад сонирхлыг тэнцвэржүүлнэ.

ЭЛСЭЛТИЙН ШАЛГАЛТ-2025 НИЙГМИЙН УХААН

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

ЯВЦЫН ҮНЭЛГЭЭ Хувилбар В

Санамж: Нэгдүгээр хэсэг нь 56 сонгох даалгавартай нийт 80 оноотой. Даалгавар тус бүр 5 сонгох хариулттай. Тэдгээрийн зөвхөн нэг зөв хариултыг сонгож хариултын хуудсанд будаж тэмдэглээрэй. **Хариултын хуудасны заавартай сайтар танилцаарай.** Амжилт хүсье.

1. Цэгийн оронд тохирох хариултыг сонгоорой. /1 оноо/
..... гэдэг нь нийгэмшилтэд нөлөөлж буй хувь хүн, бүлэг, байгууллага, нийгмийн тодорхой нөхцөлүүдийн цогцыг хэлнэ.
А. Нийгэм В. Нийгэмшилт С. Нийгмийн байр суурь
D. Нийгмийн бүтэц E. Нийгэмшилтийн агент

2. “Нэг хэсэг байр суурь нь бусдаас илүү чухал бөгөөд өндөр ур чадварыг шаарддаг, хүмүүсийн сонирхлыг татахын зэрэгцээ илүү хүндлэл хүлээж байдаг” гэж аль онолын ямар эрдэмтэн үзсэн бэ? /1 оноо/
А. Шүүмжлэлт онол – К.Маркс В. Бүтэц чиг үүргийн онол – Т.Парсонс
С. Бүтэц чиг үүргийн онол – Э.Дюркгейм D. Бүтэц чиг үүргийн онол – Дэвис, Мур
E. Индивидуалист онол – Ж.Мид, Ж.Линд

3. Улс төрийн институтын үүрэгт хамаарах ойлголтуудыг сонгоно уу. /1 оноо/

- | | |
|---|-----------------------------|
| 1. Нийгмийн эв нэгдэл, зөвшилцлийг тогтоох | 2. Мэдлэг, соёлыг дамжуулах |
| 3. Бүлэг болон нийгмийг зохицуулах | 4. Боловсон хүчнийг бэлтгэх |
| 5. Нийгмийн дэг журам, аюулгүй байдлыг хангах | 6. Нийтлэг асуудлыг шийдэх |

- A. 3, 4, 5 B. 1, 3, 5 C. 3, 5, 6 D. 2, 5, 6 E. 1, 4, 5

4. Нийгмийн давхраажилтын хэв маягуудын нэг болох “Боолчлол”-ын тухай ойлголтуудын аль хэсгийн, ямар дараалалд алдаа байгааг олоорой. /1 оноо/

Хэсэг	А	Б	В
1-р хэсэг	Зөвхөн эндогами гэрлэлтийн хэлбэртэй.	Албадлагын хөдөлмөрийн харилцаанд тулгуурласан.	Нэг нь нөгөөгийнхөө өмч болдог.
2-р хэсэг	Байр сууриа өөрчлөх боломж хомс.	Түүхийн эртний үед ихэвчлэн байсан.	Байр суурь нь угсаа залгамжлах замаар олгогддог.

- A. 1-р хэсэг – В; 2-р хэсэг – Б
C. 1-р хэсэг – Б; 2-р хэсэг – А
E. 1-р хэсэг – А; 2-р хэсэг – А
B. 1-р хэсэг – А; 2-р хэсэг – В
D. 1-р хэсэг – А; 2-р хэсэг – Б

5. Дараах ойлголтуудаас тоон судалгаанд аль нь хамаарах вэ? /1 оноо/

- | |
|---|
| 1. Цөөн тооны хувьсагч хоорондын хамаарлыг шалгахад анхаарна. |
| 2. Судлагчдын яриа, үйлдлээс хамаарсан олон тооны хувьсагч байна. |
| 3. Мэдээлэл цуглуулах үйл явц нэг ижил горимоор явагдана. |
| 4. Хэмжилт мэдээлэл цуглуулах явцад эсвэл дараа нь хийгдэнэ. |
| 5. Стандартчилалдсан загварын дагуу үр дүнг бичих албагүй. |

- A. 2, 3 B. 1, 3 C. 3, 5 D. 2, 4 E. 1, 4



6. Дараах хүснэгтээс нэлэнхүй судалгааны жишээ болон тодорхойлолтыг олно уу. /1 оноо/

Хүснэгт-а		Хүснэгт-б	
1	Хүн ам, орон сууцны тооллого явуулах судалгаа	1	Хувьсагчийг хэмжих, шинжлэх хувь хүн, бүлэг, байгууллага зэргийг хэлнэ.
2	УБ хотын бүх өрхийн ам бүлийн тоо, орлого зэргийг тоогоор илэрхийлнэ.	2	Эх олонлогийг бүхэлд нь хамруулах судалгаа.
3	Нийслэлийн өрхийг судлах бол УБ хотын бүх өрх хамаарна.	3	Судалгаа чиглэж бүх нэгжүүдийг хэлнэ.

- A. a-3, b-1 B. a-2, b-2 C. a-1, b-2 D. a-2, b-1 E. a-1, b-3

7. Мэдээлэл цуглуулах аргуудыг тохирох өгөгдөлтэй нь зөв харгалзуулна уу. /2 оноо/

a) Туршилт	1	Баримт бичгээс тодорхой утгын нэгжийг хувьсагчаар сонгон, давтамж, хоорондын хамаарлыг статистик шинжилгээ ашиглан шинжлэх арга.
b) Контент анализ	2	Сонирхож буй хувьсагч хоорондын хамаарлыг илрүүлэхээр зохиомол орчин бүрдүүлэх замаар судлах арга
	3	Тодорхой сэдэв, асуудлыг бүлгийн хүрээнд хэлэлцүүлэг өрнүүлэх замаар мэдээлэл цуглуулах арга юм.
c) Баримт бичгийн чанарын шинжилгээ	4	Судалгаанд оролцогчдын зан үйл, үйлдэл, зан төлөв, үг яриа, хөдөлгөөн зэргийн талаар тэмдэглэл хөтлөх замаар мэдээлэл цуглуулах арга.
	5	Цаг хугацаа, орон зайнаас үл хамааран судлах боломжийг олгодгоороо давуу талтай.

- A. a2, b5, c1 B. a2, b1, c5 C. a3, b5, c1 D. a4, b1, c5 E. a5, b4, c1

8. Ураг төрлийн холбоонд тулгуурлахаа больж, төр үүсэж, бичиг үсэг хэрэглэх болж мөнгөн гүйлгээ ашиглах болсон нийгмийн байгуулал аль нь вэ? /1 оноо/

- A. Цэцэрлэг аж ахуйн нийгэм B. Ан агнуурын нийгэм
C. Газар тариалангийн нийгэм D. Аж үйлдвэржсэн нийгэм
E. Аж үйлдвэржсэний дараах нийгэм

9. Т.Билтон нарын тодорхойлсон “Орчин үеийн буюу аж үйлдвэржсэн нийгэм”-ийн шинжүүдийг олоорой. /2 оноо/

Орчин үеийн буюу аж үйлдвэржсэн нийгэм	1	Уламжлалт төрийн бүтэцтэй бөгөөд шашны болон домгийн итгэл үнэмшлийн тогтолцоотой.
	2	Хувийн хүсэл зориг гэхээсээ нийгэм-хамт олны зарчимд нийцүүлэн хувь хүн амьдардаг.
	3	Хүний амьдралын үйл ажиллагааны гол талбар нь өрх гэр, гэр бүлийн хүрээ байна.
	4	Нийгэм-хамт олны зарчимд нийцүүлэх гэхээсээ хувийн хүсэл зоригийг хэрэгжүүлэхийг эрхэмлэдэг.
	5	Олон нийтийн байгууллагын хүрээнд олон янзын үүрэг хүлээж, олон талт харилцаа бүхий байна.

- A. 2, 5 B. 3, 4 C. 1, 5 D. 4, 5 E. 3, 5

10. Соёлын бүрдэл элементүүдийн нэг болох “Үнэлэмж”-ийн тухай жишээг олоорой. /1 оноо/
- A. Дэг журам, хууль дүрэм, ёс заншил
 - B. Үлгэр домог, шашин, урлаг, шинжлэх ухаан
 - C. Шударга ёс, хүний эрх, эрдэм боловсрол
 - D. Тэмдэглэсэн үг, өгүүлбэр, бичвэр, дохио зангаа
 - E. Ард Аюушийн хөшөө, Чингис хааны хөшөө

11. “Үнэлгээ” гэсэн ойлголтод хамаарах утгыг олоорой. /1 оноо/
- A. Өмнөх үеийг бүтээсэн нийгэм-соёлын уламжлалыг өвлүүлэх нь нийгмийн оршихуйн үндэс юм.
 - B. Хүмүүс үзэл санаа, итгэл үнэмшил, өөрийн тодорхой байр суурь, ёс суртахууны хувьд харилцан адилгүй сонголт хийх үйл явц.
 - C. Нийгэмд үйлчилж байдаг хэм хэмжээг эзэмшсэнээр хүмүүс амьдралын чиг баримжаагаа олж авдаг.
 - D. Нийгмийн бүлэг, бие хүний зан төлөв, үйлдлийг тодорхой шалгуурт нийцэж байна уу, үгүй юу гэдгийг шүүн тунгаах үйл явц.
 - E. Аливаа зүйлийн үнэн эсэхийг шалган тодорхойлох тусгах арга, аргачлал зарчимд тулгуурладаг.

12. Сонгодог соёлд хамаарах жишээг олоорой. /1 оноо/

1. Уран зураг	2. Радио, телевиз	3. Поп, хит дуу
4. Ардын дуу, бүжиг	5. Симфони найрал хөгжим	6. Бүжгийн жүжиг

- A. 1, 5, 6 B. 1, 3, 5 C. 1, 2, 4 D. 2, 5, 6 E. 3, 5, 6

13. Соёлын өвийн тухай ойлголтуудын аль хэсгийн, ямар дараалалд алдаа байгааг олоорой /2 оноо/

Хэсэг	A	Б
1-р хэсэг	Соёлын биет болон биет бус өв нь хоорондоо салшгүй холбоотой.	Олон жилийн туршид биет бус өвд анхаарлаа хандуулж ирсэн.
2-р хэсэг	Үндэстэн, угсаатны соёлын өвийг судалдаг олон эх сурвалж байдаг.	Соёлын өв нь дэлхийн соёлын олон янз байдлыг бий болгодог.

- A. 1-р хэсэг – Б B. 1-р хэсэг – А C. 2-р хэсэг – Б
D. 2-р хэсэг – А E. 1-р хэсэг – А; 2-р хэсэг – Б

14. Монгол улс “Соёлын үйлдвэрлэл” үндэсний хөтөлбөрийг 2015 онд батлан хэрэгжүүлж эхэлсэн. Энэхүү хөтөлбөрт тусгасан хэсгийг олоорой. /2 оноо/

Хэсэг	A	Б
1-р хэсэг	Соёлын үйлдвэрлэл эрхлэх таатай нөхцөлийг бүрдүүлэх.	Соёлын салбарт хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх
2-р хэсэг	Орон нутгийн хүн амын амьжиргаа, нийгэм эдийн засгийн хөгжилд үр ашгаа өгөх	Соёлын солилцоонд тулгуурлах

- A. 1-р хэсэг – Б; 2-р хэсэг – А B. 1-р хэсэг – А; 2-р хэсэг – А
C. 1-р хэсэг – А; 1-р хэсэг – Б D. 1-р хэсэг – Б; 2-р хэсэг – Б
E. 1-р хэсэг – А; 2-р хэсэг – Б

15. Цэгийн оронд тохирох хариултыг сонгоорой. /1 оноо/
- Хүснэгт дэх жишээг ажиглаад соёлын өөрчлөлтөд нөлөөлөх хүчин зүйлсийн дүтүүг гүйцээгээрэй.

Соёлын өөрчлөлт
	Кирилл бичигтэй болсон нь
	Дэлхийн дулаарал, байгаль цаг уурын онцлог

- A. Буруу хэвшил, шударга бус явдал ихэссэн нь
- B. Зохисгүй хэрэглээ, авлига, гэмт хэрэг ихсэх болсон нь
- C. Нуур цөөрөм ширгэх, цөлжилт явагдах болсон нь
- D. 1903 онд агаарын тээвэр зохион бүтээгдсэн нь
- E. Өндөр хэрэглээнд хэт их ач холбогдол өгдөг болсон нь

16. Цэгийн оронд тохирох хариултыг сонгоорой. /1 оноо/
- Соёлуудын нэгдэн нягтрах үйл явц бидний амьдрал, нийгмийг бүхэлд нь хамардаг. Энэ үзэгдлийг бүхэлд нь гэдэг ойлголтоор илэрхийлдэг.
- A. соёлын үйлдвэрлэл
 - B. соёлын даяаршил
 - C. соёлын адилсал
 - D. соёлын дархлаа
 - E. соёлын нэвчилт


17. Соёлын эрх чөлөөний суурь зарчмыг сонгоорой. /2 оноо/

Соёлын эрх чөлөөний суурь зарчим	1	Амьдралын хэв маягийг үгүйсгэх
	2	Бүх соёлыг ижил тэгш үнэлж, хүндэтгэх
	3	Хувь хүний сонголт хийх бололцоог өргөжүүлэх
	4	Нийгмийн амьдрал дахь оролцоог хязгаарлах
	5	Өөрийн соёлын бүтээн түүрвэх бололцоог эдлэх

- A. 1, 3 B. 2, 5 C. 2, 3 D. 2, 4 E. 4, 5

18. Дараах тохиолдлыг уншаад “Харь соёлд дасан зохицох үе шат”-ын аль үе шат дээр явж буйг тодорхойлоорой. /2 оноо/

График №1 /Харь соёлд дасан зохицох үе шат/



Тохиолдол

Баяр МУИС -ыг 2023 онд төгссөн бөгөөд Япон улсад үргэлжлүүлэн суралцахаар болов. 2024 оны 1-р сард Японд очиход тухайн улсын хоол хүнс, орчин зэрэг шинэ зүйлсийг хүлээн авч чадахгүйгээс болж бухимдаж эхэлсэн.

- A. E-үе шат B. B-үе шат C. C-үе шат D. F-үе шат E. A-үе шат

19. Цэгийн оронд тохирох хариултыг сонгоорой. /1 оноо/
- нь ямар нэг компанийн өмчийн тодорхой хэсгийг эзэмшиж буйг гэрчилсэн баримт юм.

- A. Үнэт цаас B. Бонд C. Хувьцаа D. Үнэт цаасны эмисс E. Брокер

20. Бүтцийн ажилгүйдлийн жишээг олно уу. /1 оноо/
- A. Г нь барилга дээр ажилладаг ч өвлийн улиралд ажил нь түр хугацаагаар зогссон тул хугацаагаар ажилгүй байгаа.
- B. Д-н цалин нь амьдралд хүрэлцэхгүй байгаа тул өөр өндөр цалинтай ажил хайхаар ажлаасаа гарсан.
- C. А-н нөхөр нийслэлд ажиллахаар томилогдсон тул А нь хотод ирээд хэсэг ажилгүй болсон.
- D. "F" корпорацийн хөрөнгө оруулалт буурсантай холбоотой томоохон уурхай хаагдаж уурхайчид ажлаа алдсан.
- E. Д хүссэн ажлаа хийхийн тулд гадаад хэл (Герман, Англи) суралцахаар ажлаас завсардсан.

21. Бизнесийн төлөвлөгөөний бүтэц, үе шатын нэг болох "Бизнесийн зорилго" хэсэгт хамаарч буй ойлголтыг олоорой. /1 оноо/

- | | |
|------------------------------|------------------------------|
| 1. Бизнесийн хэлбэр, байршил | 2. Ажиллах хүч, бүтэц |
| 3. Үр ашиг, татвар | 4. Бүтээгдэхүүний тоо хэмжээ |
| 5. Борлуулалтын орлого | 6. Бизнесийн хүрэх үр дүн |

- A. 1, 6 B. 2, 4 C. 3, 5 D. 2, 6 E. 1, 3

22. Хүснэгт дэх мэдээллээс Ф.Хайекын үзэл баримтлалыг олоорой. /2 оноо/

Хэсэг	А	Б
1-р хэсэг	Мөнгөний хэмжээ болон үнийн түвшний хооронд шууд холбоо байхгүй.	Төрийн идэвхтэй оролцоо нь эдийн засагт хор учруулна.
2-р хэсэг	Төрийн оролцоотой нийт эрэлтийг нэмэгдүүлэх ёстой.	Зах зээлийн тогтолцоо нь эдийн засгийн уналтаас өөрийгөө аварч чадахгүй.

- A. 1-р хэсэг – А; 1-р хэсэг – Б B. 1-р хэсэг – А; 2-р хэсэг – А
- C. 1-р хэсэг – Б; 2-р хэсэг – А D. 1-р хэсэг – Б; 2-р хэсэг – Б
- E. 1-р хэсэг – А; 2-р хэсэг – Б

23. 2023 онд Монгол улсын экспорт нь 520 тэрбум төгрөг, импорт нь 480 тэрбум төгрөг байсан бол тус оны МУ-ын гадаад худалдааны нийт эргэлтийг тооцоолно уу. /1 оноо/
- A. 840 B. -1000 C. 160 D. -160 E. 1000

24. Мөнгөний үндсэн шинжид аль нь хамаарах вэ? /1 оноо/
- A. Авч явахад хялбар байх B. Төлбөрийн хэрэгсэл C. Өртгийн хэмжүүр
- D. Хуримтлалын хэрэгсэл E. Арилжааны буюу гүйлгээний хэрэгсэл

25. Иргэн Б сард 1 сая 200 мянган төгрөгний цалин авдаг. Захирал нь урамшуулал болгон түүний цалинг 120 мянган төгрөгөөр нэмэгдүүлэх шийдвэр гаргасан. Гэтэл энэ үед бараа үйлчилгээний үнийн түвшин 10 хувиар өссөн. Энэ тохиолдолд түүний бодит цалин хэд вэ? /2 оноо/
- A. 1,320,000 төгрөг B. 1,090,909 төгрөг C. 1,210,909 төгрөг
- D. 1,188,000 төгрөг E. 1,200,000 төгрөг

26. Хөдөлмөрийн зах зээлд цалингийн түвшин 300 мянган төгрөг болж өсөхөд хөдөлмөрийн нийлүүлэлт 200 нэгж байсан. Энэ үед хөдөлмөрийн эрэлт 400 нэгж байхад ямар үзэгдэл бий болох вэ? /2 оноо/

- A. Ажиллах хүчний илүүдэл бий болно (300 нэгжээр өснө)
- B. Ажиллах хүчний илүүдэл бий болно (200 нэгжээр өснө)
- C. Ажиллах хүчний хомсдол бий болно (300 нэгжээр буурсан)
- D. Ажиллах хүчний хомсдол бий болно (200 нэгжээр буурсан)
- E. Ажиллах хүчний илүүдэл бий болно (600 нэгжээр өссөн)

27. ДНБ-ий өсөлтийг онуудаар харуулж буй хүснэгтийг ажиглаад, "Абсолют цэвэр өсөлт" болон "Өсөлтийн хурд"-ыг тооцоолоорой. /2 оноо/

Дараах томъёонуудаас сонгон бодолтыг хийгээрэй.

$$Y_n - Y_{n-1}; \quad \frac{Y_n}{Y_{n-1}}; \quad \frac{Y_n}{Y_{n-1}} \times 100\%; \quad \frac{Y_n}{Y_{n-1}} \times 100\% - 100\%;$$

Он	Үсгэн гэмдэглэгээ	ДНБ, тэрбум төгрөг	Абсолют цэвэр өсөлт	Өсөлтийн хурд
2022	Y_{2022}	31,800,0	-	-
2023	Y_{2023}	34,200,0	a.....	b.....

- A. a-2,400,0; b-7 B. a-2,400,0; b-107 C. a-2,400,0; b-1.07
- D. a-107; b-2,400,0 E. a-1.07; b-2,400,0

28. Цэгийн оронд тохирох хариултыг сонгоорой. /1 оноо/
- УИХ нь зохион байгуулалтын хувьд-д хуваагдана.
- A. Танхим B. Байнгын хороо C. Хэлэлцүүлэг D. Хэвлэл мэдээлэл E. Уулзалт

29. Цэгийн оронд тохирох хариултыг сонгоорой. /1 оноо/
- Манай улс хоёрдугаар үндсэн хуулиа шинээр батлан гаргажээ.
- A. 1960 онд B. 1924 онд C. 1940 онд D. 1990 онд E. 1992 онд

30. "Төлөөллийн ардчилал" гэсэн ойлголтыг аль нь илэрхийлж байна вэ? /2 оноо/
- A. Хэн нэгэн хүн хэтэрхий их эрх мэдэл эдлэхээс сэргийлдэг ардчиллын хэлбэр
- B. Олон түмэн өөрөө өөрийгөө удирдаж, иргэн бүрийг төрийн хэрэгт оролцуулдаг хэлбэр
- C. Аливаа асуудлаар бүх иргэн саналаа илэрхийлэх боломжтой байдаг хэлбэр
- D. Албан тушаалтныг сонгож, түүгээр дамжуулж засаглалыг хэрэгжүүлэх хэлбэр
- E. Иргэдийн улс төрд оролцох идэвх, сонирхол өсдөг ардчиллын хэлбэр.

31. 1990 оноос өмнөх төрийн бодлогуудыг сонгоорой. /2 оноо/

Хэсэг	А	Б
1-р хэсэг	Улс түмний харилцан ашигтай хамтын ажиллагааг эрхэмлэх	Хүний эрхийн түгээмэл зарчмуудыг ёс төдий тунхаглах
2-р хэсэг	Төвлөрсөн төлөвлөлтөөр нийгмээ хөгжүүлэх	Олон ургалч үзлийг хүлээн зөвшөөрч олон намын тогтолцоог чухалчлах

- A. 1-р хэсэг – А; 2-р хэсэг – Б B. 1-р хэсэг – А; 2-р хэсэг – А
- C. 1-р хэсэг – А; 1-р хэсэг – Б D. 1-р хэсэг – Б; 2-р хэсэг – Б
- E. 1-р хэсэг – Б; 2-р хэсэг – А

32. Д.Истоны улс төрийн системийн оролтын нэг болох “Бодит дэмжлэг” гэсэн ойлголтыг аль нь илэрхийлж байна вэ? /2 оноо/
- A. Татвар төлөх, төрийн болон цэргийн алба хаших, хууль дүрмийг дагаж мөрдөх
 B. Төрийн бодлогын тодорхой илрэл болсон төрийн хууль тогтоомж, мэдээлэл гэх мэт
 C. Нийгмийн хурцадмал, тогтворгүй байдлыг арилгах гол механизмын үүргийг гүйцэтгэдэг
 D. Улс төрийн систем, түүнийг хүрээлэн байгаа экологи, соёл зэрэг янз бүрийн тулгалтууд
 E. Аль нэг нам, нэр дэвшигчийн төлөө санал өгөх, шийдвэрийг дэмжиж буйгаа илэрхийлэх

33. Хэм хэмжээ зохицуулалтын дэд системд тохирох өгөгдлийг сонгоно уу. /2 оноо/

Хэм хэмжээ зохицуулалтын дэд систем	1	Улс төрийн системийн бүрдэл хооронд холбоо тогтоох
	2	Хүмүүсийн үйлдэл болон бусад объектын чиг үүргийг тодорхойлох
	3	Төр, нам, сонирхлын бүлэг зэрэгтэй хамгийн түрүүнд холбогдох.
	4	Төр болон улс төрийн институтэд мэдээлэл дамжуулах.
	5	Хууль тогтоох үйл явцыг тодорхойлж үг хэлэх эрхийг тогтоох.

- A. 2, 5 B. 1, 5 C. 3, 4 D. 1, 4 E. 2, 4

34. “Улс төр бол эрх мэдэлд хүрэх, эрх мэдлийг тогтоон барьж байх ба ашиг хонжоо олохын тулд эрх мэдлийг ашигладаг албадлагын арга хэрэгслийн цогц юм” гэж хэн үзсэн бэ? /1 оноо/
- A. Монтесьеке B. Истон C. Локк D. Макиавелли E. Даль

35. Ардчилсан сонгуулийн тэгш оролцох зарчмыг аль нь илэрхийлж байна вэ? /1 оноо/
- A. Сонгуулийн үр дүн нь зөвхөн иргэдийн санал хураалтын үр дүнгээр шийдэгддэг байх
 B. Нас, хүйс, яс үндэс, гарал угсаа зэрэг үзэл бодлоос үл шалтгаалан бүгд оролцдог байх
 C. Сонгогч бүр ижил тооны санал гаргах эрхтэй бөгөөд санал бүр адил жинтэй байх
 D. Сонгуульд оролцохдоо чөлөөтэй сонголтоо хийн, саналаа чөлөөтэй илэрхийлдэг байх
 E. Сонгогч ямар нэгэн дарамт шахалтгүйгээр өөрийн үзэмжээр саналаа өгдөг байх

36. Улс төрийн намын нийгэмд гүйцэтгэх үүрэгт аль аль нь хамаарах вэ? /2 оноо/

Хэсэг	А	Б
1-р хэсэг	Иргэдийн оролцоог хангах	Төр, эдийн засаг, гэр бүлээс ангид оршино
2-р хэсэг	Бодлогын хэрэгжилтээ тайлагнах, хариуцлага хүлээх	Нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд иргэдийн боломжийг хязгаарлах

- A. 1-р хэсэг – А; 2-р хэсэг – Б B. 1-р хэсэг – А; 2-р хэсэг – А
 C. 1-р хэсэг – А; 1-р хэсэг – Б D. 1-р хэсэг – Б; 2-р хэсэг – Б
 E. 1-р хэсэг – Б; 2-р хэсэг – А

37. Онцгой ашиг сонирхлоо хэрэгжүүлэх зорилгоор төрийн байгууллагуудад сонирхлын бүлгүүд зорилго чиглэл бүхий нөлөө үзүүлэхийг юу гэж нэрлэдэг вэ? /1 оноо/
- A. Сонирхлын бүлэг B. Улс төрийн нам C. Лоббизм
 D. Иргэний нийгэм E. Аномик бүлэг

38. Төр бол “левиафан” юм. Энэ нь дараах эрдэмтдийн хэнийх нь үзэл баримтлал вэ? /1 оноо/
- A. Л.Актон B. Т.Гоббс C. Р.Нозик D. Ж. Локк E. Ж. Руссо

39. Доорх ойлголтуудаас хүний эрхэм чанарт аль нь хамаарахгүй вэ? /1 оноо/
- A. Хүний эрхэм чанарт халдаж болохгүй.
 B. Хүний эрхэм чанар нь хүн бүрд адилхан байдаг.
 C. Хүнээс хүний эрхэм чанарыг нь салгаж болдоггүй.
 D. Хүний эрхэм чанар нь хуваагдмал шинжтэй байдаг.
 E. Хүний эрхэм чанар нь үл хэмжигдэх үнэт зүйл.

40-42 дугаар даалгаврыг доорх кэйсийг уншиж гүйцэтгээрэй.

Иргэн Д нь барилгын инженер бөгөөд туслах ажилтан авахаар зар оруулжээ. Тухайн зарыг сайн дураар даатгуулагч (14 сар нийгмийн даатгалын шимтгэл төлсөн) иргэн О (36 настай) хараад, иргэн Д буюу ажил олгогчтой уулзаж барилгын туслах ажилтнаар ажиллах болсон. Харин ажил олгогч Д нь ажилтан О-той хөдөлмөрийн гэрээ байгуулалгүй ажлын чиг үүрэг өгсөн байна.

40. Ажил олгогч Д нь ажилтан О-оос ажил үүрэг гүйцэтгэхийг шаардаж болох уу? /1 оноо/
- A. Хөдөлмөрийн гэрээ байгуулаагүй ч гэсэн ажилтнаас ажил үүрэг гүйцэтгэхийг шаардаж болно.
 B. Иргэн О нь барилгын туслах ажилтнаар ажилд орсон тул хөдөлмөрийн гэрээ байгуулах шаардлагагүй тул, ажил үүргээ гүйцэтгэж болно.
 C. Ажил олгогч Д нь үндсэн хуулийн 16-р зүйлийг үндэслэн ажилтан О-г барилгын туслах ажилтнаар ажиллуулж болно.
 D. Ажил олгогч Д нь хөдөлмөрийн тухай хуулийн 53-р зүйлийг үндэслэн ажилтан О-г барилгын туслах ажилтнаар ажиллуулж болно.
 E. Хөдөлмөрийн гэрээг бичгээр байгуулаагүй бол ажилтнаас ажил үүрэг гүйцэтгэхийг шаардаж болохгүй
41. Хэрвээ Д нь сахилгын зөрчил гаргасан бол хэдэн сарын дотор шийтгэл ноогдуулах ёстой вэ? /2 оноо/
- A. Зөрчил гарснаас хойш 6 сарын дотор, зөрчлийг илрүүлснээс хойш 1 сарын дотор
 B. Зөрчил гарснаас хойш 7 сарын дотор, зөрчлийг илрүүлснээс хойш 2 сарын дотор
 C. Зөрчил гарснаас хойш 8 сарын дотор, зөрчлийг илрүүлснээс хойш 3 сарын дотор
 D. Зөрчил гарснаас хойш 9 сарын дотор, зөрчлийг илрүүлснээс хойш 4 сарын дотор
 E. Зөрчил гарснаас хойш 10 сарын дотор, зөрчлийг илрүүлснээс хойш 5 сарын дотор
42. Хэрвээ иргэн О нь жирэмсэн байсан бол жирэмсэн болон амаржсаны тэтгэмжийг цалингийн хэдэн хувиар тооцон нийгмийн даатгалын сангаас авах ёстой вэ? /2 оноо/
- A. 12 сарын цалингийн дунджийг 70 хувиар тооцож 4 сарын цалин авна.
 B. 12 сарын цалингийн дунджийг 100 хувиар тооцож 4 сарын цалин авна.
 C. 14 сарын цалингийн дунджийг 100 хувиар тооцож 4 сарын цалин авна.
 D. 14 сарын цалингийн дунджийг 70 хувиар тооцож 4 сарын цалин авна.
 E. 10 сарын цалингийн дунджийг 70 хувиар тооцож 4 сарын цалин авна.

43. Захиргааны актын агуулгын шаардлагад хамааралгүй ойлголтыг олно уу /2 оноо/

Хэсэг	А	Б
1-р хэсэг	Эрх зүйн хувьд үндэслэлтэй байх	Ямар ч хүнд ойлгомжтой, хэрэгжих боломжтой байх
2-р хэсэг	Хаяглагч буюу хандсан этгээдийг зөв сонгосон байх	Хэлбэрийн шаардлагыг хангасан байх

- A. 1-р хэсгийн Б В. 2-р хэсгийн А С. 1-р хэсгийн А
D. 2-р хэсгийн Б Е. 2-р хэсгийн А, Б

44. Захиргааны шийтгэлд хамаарах жишээнүүдийг сонгоно уу. /2 оноо/

Захиргааны шийтгэл	1	Д замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн тул 20 нэгжээр торгуулав.
	2	А ажлаа дараалан тасалж цалингийнхаа 20 хувийг хасуулав.
	3	Н ажил дээрээ согтууруулах ундаа хэрэглэсэн тул ажлаасаа халагдав.
	4	О ёс бус үйлдэл гаргасан тул сануулах арга хэмжээ авхуулав.
	5	А олон нийтийн газар танхайрсан тул баривчлагдав.

- A. 3, 4 В. 1, 4 С. 1, 5 D. 2, 5 Е. 2, 4

45. “Хүний аливаа эрх, өмчлөх эрх дээр хураангуйлагддаг” гэж хэн үзсэн бэ? /1 оноо/

- A. Э.Дюркгейм В. Н.Ротбард С. Ж.Локк D. Ж.Руссо Е. Л.Актон

46. Өмчлөх эрх үүсэх хуульд заасан үндэслэлүүдийг олоорой. /1 оноо/

- A. Авто тээврийн хэрэгслийг зөвшөөрөлгүйгээр авч явах
B. Ирээдүйд эд хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ
C. Эд хөрөнгө нийлж, холилдох, гээгдэл эд хөрөнгийг олж авах
D. Нотариатч, улсын бүртгэгч өмчлөлийн эрхийг зөрчих
E. Алдаатай гүйлгээ, андуурагдсан илгээмж, адуу мал завших

47. Засгийн газрын үйл ажиллагааны тухай ойлголтуудын аль хэсгийн, ямар дараалалд алдаа байгааг олоорой. /2 оноо/

Хэсэг	А	Б
1-р хэсэг	Хүний эрхийн талаар хууль тогтоомж олон улсын гэрээний биелэлтийг хангах	Зөрчигдсэн эрхийг сэргээх, хохирлыг нөхөн төлүүлэх
2-р хэсэг	Хүний эрхийн талаарх хууль тогтоомжийн биелэлтийн үр дүнг УИХ-д тайлагнах	Хууль тогтоох замаар хүний эрхийг хангах

- A. 1-р хэсэг – А; 2-р хэсэг – Б В. 1-р хэсэг – Б; 2-р хэсэг – Б
C. 1-р хэсэг – А; 1-р хэсэг – Б D. 1-р хэсэг – А; 2-р хэсэг – А
E. 1-р хэсэг – Б; 2-р хэсэг – А

48. Олон улсын улс төр, эрх зүй, эдийн засаг, соёлын зэрэг олон талт харилцаанд гадаад бодлогоороо дамжуулан оролцох үйл ажиллагааны цар хүрээ, нөлөөллөөр тодорхойлогддог ойлголтыг юу гэж нэрлэдэг вэ? /1 оноо/

- A. Олон улсын харилцаа В. Олон улсын харилцаанд оролцох нөлөө
C. Иргэн олон улсын харилцааны оролцогч D. Олон улсын харилцаанд оролцох үүрэг
E. Олон улсын харилцаанд оролцох үйл ажиллагааны чиглэл

49. Олон улсын харилцааны улс бус оролцогчдод аль нь хамаарахгүй вэ? /1 оноо/

- A. Олон улсын төрийн бус байгууллага В. Нөлөө бүхий хувь хүн С. Шашны байгууллага
D. Үндэстэн дамнасан корпорациуд Е. Дунд улс

50. Цэгийн оронд тохирох хариултыг сонгоорой. /1 оноо/

- 1991 оны Персийн булангийн үйл явцын талаар дайны талбараас шуурхай мэдээ хүргэснээр дэлхийн улс орнуудад бодит мэдээллийг газар дээрээс нь шууд хүргэх эхлэл болсон.
- A. CNN В. BBC С. NHK D. SBS Е. CCTV

51. Бага улсын тухай мэдээлэл нь аль хэсгийн, ямар дараалалд алдаагүй байгааг олоорой. /2 оноо/

Хэсэг	А	Б
1-р хэсэг	Голчлон тогтвортой эдийн засгийн хөгжилтэй улсууд	Бүс нутгийн аюулгүй байдлыг хангах хүчин чадалтай
2-р хэсэг	Олон улсын харилцаанд нөлөө багатай	Дэлхийн улсуудын 2/3 хувийг эзэлдэг

- A. 2-р хэсэг – А; 2-р хэсэг – Б В. 1-р хэсэг – А; 2-р хэсэг – Б
C. 1-р хэсэг – Б; 2-р хэсэг – А D. 2-р хэсэг – Б; 1-р хэсэг – Б
E. 1-р хэсэг – А; 2-р хэсэг – А

52. Аль хэсгийн ямар дараалалд зөөлөн хүчний төрлүүдийг дурдсан байна вэ? /2 оноо/

Хэсэг	А	Б
1-р хэсэг	Бизнес, инноваци	Эдийн засгийн хүч, урамшуулал
2-р хэсэг	Удирдамж	Боловсрол

- A. 1-р хэсэг – Б; 2-р хэсэг – А В. 2-р хэсэг – Б; 1-р хэсэг – Б
C. 1-р хэсэг – А; 2-р хэсэг – Б D. 2-р хэсэг – А; 2-р хэсэг – Б
E. 1-р хэсэг – А; 2-р хэсэг – А

53. Олон улсын байгууллагын үйл ажиллагааны цар хүрээний ойлголтуудын аль хэсгийн, ямар дараалалд алдаа байгааг тодорхойлоорой. /2 оноо/

Хэсэг	А - /Глобал түвшин/	Б - /Бүс нутгийн түвшин/
1-р хэсэг	ЮНЕСКО	Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн
2-р хэсэг	Европын холбоо	ШХАБ

- A. 1-р хэсэг – А; 2-р хэсэг – Б В. 1-р хэсэг – Б; 2-р хэсэг – А
C. 1-р хэсэг – А; 1-р хэсэг – Б D. 1-р хэсэг – А; 2-р хэсэг – А
E. 1-р хэсэг – Б; 2-р хэсэг – Б

54. Mazda, Walmart, Emart гэх мэт байгууллагууд нь улс бус оролцогчдын алинд нь хамаарах вэ? /1 оноо/

- A. Олон улсын гэмт хэргийн сүлжээ В. Олон улсын байгууллага
C. Олон улсын төрийн бус байгууллага D. Үндэстэн дамнасан корпораци
E. Олон улсын хэвлэл мэдээллийн сүлжээ

55. Монгол улсын олон улсын хамтын нийгэмлэг дэх үйл ажиллагааны чиглэлийг зөв дараалалд оруулан эрэмбэлнэ үү? /2 оноо/

- a) Хөгжиж буй орнуудтай нийтлэг зорилтын хүрээнд хамтран ажиллах
- b) Хөрш орнуудтайгаа найрсаар харилцах
- c) НҮБ болон түүний төрөлжсөн байгууллагууд ОУВС, ДБ, АХБ-тай хамтран ажиллах
- d) Өрнө, дорнын өндөр хөгжилтэй гүрнүүдтэй найрсаг харилцаа хөгжүүлэх
- e) Социализмын дараах орнууд, ТУХН-ийн орнуудтай найрсаг харилцаа хөгжүүлэх
- f) Азийн бүс нутгийн улс төр, эдийн засгийн интеграцид оновчтой оролцох



- A. 1b,2a,3f,4d,5c,6e
- B. 1e,2b,3f,4d,5a,6c
- C. 1b,2f,3d,4a,5c,6e
- D. 1b,2e,3f,4d,5a,6c
- E. 1e,2b,3a,4f,5d,6c

56. Хоёр хөрштэйгөө харилцах зарчмуудад аль нь хамаарахгүй вэ? /1 оноо/

- A. Хамтын ажиллагааны
- B. Боловсролын
- C. Олон тулгуурт
- D. Тэнцвэртэй, найрсаг
- E. Стратегийн түншлэлийн

ХОЁРДУГААР ХЭСЭГ

Санамж: Хоёрдугаар хэсэг нь 4 даалгавартай нийт 20 оноотой. **Хариултын хуудасны заавартай сайтар танилцаарай.**

2.1. Дараах ойлголтуудыг тохирох өгөгдөлтэй нь харгалзуулна уу. /5 оноо/

a) Нийгмийн ялгарал b) Нийгмийн давхраажилт c) Нийгмийн нийтлэг d) Тэгш бус байдал e) Нийгмийн давхраа	1	Баялаг, нэр хүнд, эрх мэдлийн хувьд ялгаатай, тодорхой хэв шинжит харилцаа бүхий нийгмийн нийтлэг
	2	Тодорхой хэв шинжит харилцаа бүхий тэгш бус байдлын тогтолцоо
	3	Нэг бүлэгт давуу боломж олгосон атлаа нөгөөгийнх нь боломжийг хааж буй бодит үйлдэл.
	4	Эдийн засгийн баялаг, нэр хүнд, эрх мэдэлд хүрэх адил бус боломж бүхий байдал
	5	Нийгмийн гишүүд хувийн болон нийгмийн шинжээрээ зааглагдан хуваагдах үйл явц
	6	Ижил төстэй шинж бүхий хүн амын статистик нэгдэл

2.2. Дараах ойлголтуудыг тохирох өгөгдөлтэй нь харгалзуулна уу. /5 оноо/

a) Лоббизм b) Аномик бүлэг c) Эвсэл холбооны бүлэг d) Байгуулагдажсан бүлэг e) Эвсэл холбооны бус бүлэг	1	Өөрийн гэсэн тодорхой зорилго, чиглэлд үндэслэгдсэн зохион байгуулалттай бүлэг
	2	Зохион байгуулалтгүй боловч аномик бүлгээс ялгаатай нь хүмүүс голдуу яс үндэс, арьс өнгө зэрэг нийтлэгээрээ хамрагддаг.
	3	Цэрэг зэвсэглэл, арми, сүм хийд зэрэг субъектийн шууд удирдлаган дор зохион байгуулалттай үүсгэн байгуулдаг.
	4	Тодорхой зохион байгуулалтгүй хэсэг бөөн хүмүүсийн цугларалт, бослого, үймээн
	5	Хувийн эрх ашгийн төлөө бус, нийтийн ашиг сонирхлыг илэрхийлэх зорилгоор иргэдээс сайн дураараа үүсгэн байгуулсан байгууллага
	6	Онцгой ашиг сонирхлоо хэрэгжүүлэх зорилгоор төрийн байгууллагуудад зорилго, чиглэл бүхий нөлөө үзүүлэх

2.3. Дараах ойлголтуудыг тохирох өгөгдөлтэй нь харгалзуулна уу. /5 оноо/

a) Чадамж b) Иргэний эрх зүйн харилцааны объект c) Иргэний эрх зүйн харилцааны агуулга d) Иргэний эрх зүйн харилцааны субъект e) Чадвар	1	Эдийн баялаг болох эд юмс, эдийн бус баялаг болох оюуны үнэт зүйлс, мөн эрх багтана.
	2	Иргэдийн хоорондын эд хөрөнгийн ба эд хөрөнгийн бус амины шинжтэй харилцаа.
	3	Үйлдлээр эрх олж авах, үүрэг бий болгох, үүнээс үүсэх эрх зүйн үр дагаврыг биечлэн хариуцах онцгой чадвар.
	4	Талуудын тэгш эрхийн үндсэн дээр тэдний эрх үүргээр тодорхойлогддог.
	5	Эрх эдэлж, үүрэг хүлээх ерөнхий ойлголт юм.
	6	Эд хөрөнгийн ба эд хөрөнгийн бус амины харилцаанд оролцож, хуулиар олгогдсон эрх эдэлж, үүрэг хүлээж байгаа этгээд

2.4. Дараах ойлголтуудыг тохирох өгөгдөлтэй нь харгалзуулна уу. /5 оноо/

a) Олон тулгуурт байх b) Прагматик байх c) Тэнцвэртэй байх d) Үндэсний эрх ашигт нийцсэн байх e) Улс бус оролцогч	1	Гадаад харилцаа, хамтын ажиллагаандаа нөөц бололцоог аль болох бүрэн дайчлан зохион байгуулах явдал юм.
	2	Үндэсний язгуур ашиг сонирхлыг сахин хамгаалсан үндэсний хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд үйлчилнэ.
	3	Хувийн сайн дурын үндсэн дээр бий болсон, үүрэг даалгаварт чиглэсэн олон нийтийн байгууллага юм.
	4	Засгийн газрын оролцоо, дэмжлэггүйгээр улс, үндэстэн дамнасан үйл ажиллагаа явуулдаг глобал түвшний оролцогчид.
	5	Стратегийн ач холбогдол бүхий гүрнүүдийн монгол дахь эдийн засгийн болон бусад сонирхлыг тэнцвэржүүлэхэд чиглэнэ.
	6	Олон улс оронтой хамтран ажиллах, нөгөө талаас гадаад харилцааг аль болох олон хэлбэрээр явуулахад оршино.

№	A Хувилбар	B Хувилбар	оноо
1	E	E	1
2	D	D	1
3	C	C	1
4	B	B	1
5	C	B	1
6	B	C	1
7	D	B	2
8	E	C	1
9	D	D	2
10	C	C	1
11	B	D	1
12	D	A	1
13	E	A	2
14	D	C	2
15	C	D	1
16	B	B	1
17	C	C	2
18	D	B	2
19	E	C	1
20	D	D	1
21	C	A	1
22	B	A	2
23	D	E	1
24	A	A	1
25	A	E	2
26	E	D	2
27	D	C	2
28	C	B	1
29	A	C	1
30	A	D	2
31	E	E	2
32	D	A	2
33	C	A	2
34	B	D	1
35	D	C	1
36	E	B	2
37	A	C	1

38	A	B	1
39	D	D	1
40	C	E	1
41	E	A	2
42	D	A	2
43	A	D	2
44	A	C	2
45	C	B	1
46	B	C	1
47	D	B	2
48	E	D	1
49	A	E	1
50	A	A	1
51	C	A	2
52	B	C	2
53	B	B	2
54	D	D	1
55	E	C	2
56	A	B	1
2.1	a2	a5	1
	b6	b2	1
	c1	c6	1
	d3	d4	1
	e5	e1	1
2.2	a3	a6	1
	b4	b4	1
	c6	c1	1
	d2	d3	1
	e5	e2	1
2.3	a6	a3	1
	b4	b1	1
	c1	c4	1
	d3	d6	1
	e5	e5	1
2.4	a1	a6	1
	b3	b1	1
	c6	c5	1
	d2	d2	1
	e5	e4	1